



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/57

Улаанбаатар хот

Чиглүүлэх хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 41, 43 дугаар зүйл, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/790 дүгээр захирамж, Газрын дүрмийн 7.1.1, 7.1.7, Хөдөлмөрийн дотоод журмын 5.1.3 дахь заалт, газрын даргын дэргэдэх Удирдлагын зөвлөлийн 2023 оны 6 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагад шинээр томилогдсон албан хаагчдыг төрийн албаны ёс зүй болон байгууллагын соёл, үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаанд дадлагажуулах, ажлын чиг баримжаа олгох, арга зүйгээр хангах зорилгоор “Шинэ албан хаагчдыг чиглүүлэх хөтөлбөр”-т хамруулах удирдамжийг нэгдүгээр, чиглүүлэх хөтөлбөрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Шинээр томилогдсон болон бусад төрийн байгууллагаас шилжин ажиллах албан хаагчдыг чиглүүлэх хөтөлбөрийн дагуу удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг нийт нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт, шинжилгээний хэлтэс (Г.Энхээ)-т даалгасугай.

ДАРГА

С.ТӨМӨРДУЛАМ